



**БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
XI ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2022 оны 07 сарын 07 өдөр

Дугаар Х/08

Булган сум

Сумын Амьжиргаа дэмжих зөвлөлийн  
2022 оны эхний хагас жилийн тайлан

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.6, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2021 оны А/89 дүгээр тушаалаар баталсан “Амьжиргаа дэмжих зөвлөлийн дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн XI хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын Амьжиргаа дэмжих зөвлөлийн 2022 оны эхний хагас жилийн тайланг хэлэлцээд “Хангалттай” гэж үнэлсүгэй.

2. Сумын Амьжиргаа дэмжих зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль, эрх зүйн хүрээнд зохион байгуулж, дүрэмд заасан хугацаанд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Нийгмийн бодлогын асуудал эрхэлсэн Хорооны дарга, гишүүдэд даалгасугай.

ДАРГА  Б. ГАНЗОРИГ

